



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 16 өдөр

Дугаар А/316

Мөрөн сум

Малын гоц халдварт шүлхий өвчний
дархлаажуулалтын ажлыг зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, Улсын онцгой комиссын 2022 оны 02 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын “Шүлхий өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай” 2022 оны 09 дүгээр сарын 08-ний өдрийн А/191 дугаар тушаалын хүрээнд шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг аймгийн хэмжээнд бүх үхэр, гахай, цаа бугыг хамруулан 2022 оны 9 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлэн 20 хоногийн хугацаанд зохион байгуулсугай.

2. Дархлаажуулалтын арга хэмжээний ажлын хэсгийг шуурхай зохион байгуулан шаардагдах ажиллах хүн хүч, шатахуун, автомашинаар ханган явц, гүйцэтгэлд нь өдөр тутмын хяналт тавьж ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3. Дархлаажуулалтад шаардагдах вакцин, ариутгалын бодис, хамгаалах хувцас хэрэгслийг хуваарилан олгож, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, тайлан мэдээ, акт баримтыг бүрдүүлэн холбогдох газарт хүргүүлж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Д.Нямдорж)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



М.ХУЯГБААТАР

Аймгийн Засаг даргын 2022 оны
09 дүгээр сарын 16 өдрийн А/ЗД дүгээр
захирамжийн хавсралт



ШҮЛХИЙ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ДАРХЛААЖУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ХУВААРЬ

№	Аймаг	Сум	Олгох вакцин (мян/тун)	Хайрцаг (ширхэг)	Шил (ширхэг)	ХХ-ийн хувцас (ш)		Ариутгалын бодис (л, кг)	
						МЭТ	Аж ахуйн нэгж	МЭТ (Новасид)	Аж ахуйн нэгж (Hi-Cop)
1	Хөвсгөл	Алаг-Эрдэнэ	29.4	12	294	1	12	1	3
2		Арбулаг	32.2	13	322	1	8	1	2
3		Баянзүрх	27.7	11	277	1	8	1	2
4		Бүрэнтогтох	35.2	14	352	1	28	1	7
5		Галт	33.3	13	333	1	20	1	5
6		Жаргалант	31.5	13	315	1	12	1	3
7		Их-Уул	30.1	12	301	1	24	1	6
8		Мөрөн	25.9	10	259	1	24	1	6
9		Рашаант	22.5	9	225	1	12	1	3
10		Рэнчинлүмбэ	42.1	17	421	1	4	1	1
11		Тариалан	32.1	13	321	1	16	1	4
12		Тосонцэнгэл	27.9	11	279	1	20	1	5
13		Төмөрбулаг	26.9	11	270	1	16	1	4
14		Түнэл	37.8	15	378	1	20	1	5
15		Улаан-Уул	40.3	16	403	1	16	1	4
16		Ханх	29.2	12	292	1	4	1	1
17		Хатгал	18.3	7	183	1	4	1	1
18		Цагааннуур	10.2	4	102	1	4	1	1
19		Цагаан-Уул	42.7	17	427	1	12	1	3
20		Цагаан-Үүр	22.1	9	221	1	4	1	1
21		Цэцэрлэг	32.5	13	325	1	4	1	1
22		Чандмань-өндөр	26.5	11	265	1	8	1	2
23		Шинэ-Идэр	18.3	7	18.3	1	8	1	2
24		Эрдэнэбулган	29.3	12	29.3	1	8	1	2
		Нийт	704.0	282	7041	24	300	24	74